

**ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН НЭМЖ ГАРГАСАН ХУВЬЦААГ
ХУДАЛДАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “Компани” гэх)-ийн нэмж гаргасан 106,350,000 (Нэг зуун зургаан сая гурван зуун тавин мянга) ширхэг энгийн хувьцааг худалдахад (цаашид “хувьцаа худалдах ажиллагаа” гэх) энэхүү журам (цаашид “журам” гэх)-ыг мөрдөнө.
- 1.2. Компанийн нэмж гаргасан хувьцааг компанид технологийн шинэчлэл хийхэд шаардлагатай хөрөнгийн санхүүжилтэд хамтарч ажиллах сонирхолтой хөрөнгө оруулагчдад хаалттай хэлбэрээр худалдана.
- 1.3. Хувьцааг худалдах ажиллагааг зарлах, хөрөнгө оруулагчаас санал авах, саналыг нээх, саналыг үнэлэх буюу хувьцааг худалдах үнийг тогтоож хувьцааг хуваарилах гэсэн дарааллын дагуу явуулна.
- 1.4. Компанийн хувьцааг худалдах ажиллагааг Компанийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг удирдлага болгон Төрийн өмчийн хорооноос томилсон ажлын хэсэг зохион байгуулна.
- 1.5. Компани нь нийт 106,350,000 ширхэг энгийн хувьцааг 10,635 ширхэг багц хувьцаа болгон худалдана. Нэг багц хувьцааг худалдах үнэ нь 900,000 (Есөн зуун мянга) төгрөгөөс доошгүй байна.
- 1.6. Нэг хөрөнгө оруулагч болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд худалдах хувьцааны дээд хэмжээ нь 2100 багцаас илүүгүй байна.
- 1.7. Хөрөнгө оруулагчийн нэг багц хувьцаанд санал болгох үнэ нь энэхүү журмын 1.5-д заасан үнээс багагүй байна.

Хоёр. Нэр томъёоны тайлбар

- 2.1. Энэ журамд заасан нэр томъёог дараах утгаар ойлгоно.
 - 2.1.1. “Санал” гэж энэхүү журмын Хавсралт.1-д заасан маягтын дагуу хөрөнгө оруулагчаас ирүүлсэн нэг багц хувьцаанд санал болгох үнэ болон худалдан авахыг хүсч буй хамгийн их багц хувьцааны тоог илэрхийлсэн битүүмжилсэн саналыг;
 - 2.1.2. “Гэрээ байгуулах эрх авсан этгээд” гэж энэ журмын дагуу тогтоосон хувьцааг худалдах үнээр, хуваарилсан багц хувьцааг худалдаж авахыг зөвшөөрсөн этгээдийг;
 - 2.1.3. “Нэг багц хувьцаа” гэж компанийн нэмж гаргасан 10,000 ширхэг энгийн хувьцааг;
 - 2.1.4. “Хөрөнгө оруулагч” гэж энэ журамд заасан хувьцаа худалдах ажиллагаанд оролцох урилга хүлээн авсан этгээдийг;
 - 2.1.5. “Худалдагдаагүй үлдсэн хувьцаа” гэж худалдалдан авах санал ирүүлээгүй, эсхүл энэ журмын дагуу худалдагдаагүй хувьцааг тус тус ойлгоно.

